



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ  
“ОЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ТӨВ”

# МОНГОЛ УЛСЫН ОЙН САН



*Албан хэрэгцээнд*

УЛААНБААТАР ХОТ - 2020 он

"ОЙН СУДАЛГАА ХӨГЖЛИЙН ТӨВ" УТҮГ  
Баянгол дүүрэг 2-р хороо, Чингүнжавын гудамж  
Улаанбаатар 16050. Төрийн өмчийн II байр  
Утас/факс: (976-11) 300078  
Э-мэйл хаяг: [info@forestry.gov.mn](mailto:info@forestry.gov.mn)  
Утас: 77111178

*Ойн нөөцийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны ... дугаар сарын ...-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцэн баталгаажуулав.*

## МОНГОЛ УЛСЫН ОЙН САН

Монгол улсын "Ойн тухай" хуулийн 7 зүйлийн 7.2 заалтын дагуу 2019 онд Сэлэнгэ аймгийн ой зохион байгуулалтын ажлын дүн мэдээг тусгасан улсын ойн сангийн төлөв байдлын шинэчлэгдсэн мэдээллийг албан хэрэгцээнд мөрдүүлэхээр гаргав.

Манай орны нутаг дэвсгэр дээр ургадаг бүх төрлийн мод, заг, бут, сөөг, таримал ойн нөөцөөс Монгол улсын ойн сан бүрдэх бөгөөд ой бүхий газар, ойн цоорхой, мод бэлтгэсэн болон ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, түүнчлэн ойн захаас гадагш 100 метр газар, тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газрын эзлэх талбай зэрэг нь ойн сангийн газарт хамаардаг.

Аливаа улс орны буюу тухайн газар нутгийн ойрхог чанарыг тогтоохдоо ойгоор бүрхэгдсэн талбайгаар тооцож үнэлдэг.

Манай орны ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбай 12 452.0 мян.га байгаа бөгөөд энэ нь нийт нутаг дэвсгэрийн 7.96 хувийг эзэлж байна.

Манай орны ой сан 140 гаруй зүйлийн мод, сөөгөөс бүрдэх бөгөөд 84.9 хувийг навч, шилмүүст ой, 15.1 хувийг заган ой эзэлнэ.

Ойн сангийн төлөв байдлын талаарх мэдээллийг ой сан бүхий 1 хот, 21 аймгийн хэмжээнд боловсруулан навч, шилмүүст болон заган ойн статистик үзүүлэлтүүдийг тус тусад нь тооцож 16 хавсралт хүснэгтээр гаргав.

### Үүнд

- Ойн санд ой зохион байгуулалт хийгдсэн он дараалал /Хавсралт-1/
- Ойн сангийн талбай газрын төрлөөр /Хавсралт-2/
- Ойн сангийн байгалийн ойн талбай модны төрлөөр /Хавсралт-3/
- Ойн сангийн байгалийн ойн нөөц модны төрлөөр /Хавсралт-4/
- Шилмүүст, навчит ойг насны бүлгээр ангилсан нь /Хавсралт-5/
- Заган ойг насны бүлгээр ангилсан нь /Хавсралт-6/
- Байгалийн ойн таксацын дундаж үзүүлэлт /Хавсралт-7/
- Ойн сангийн талбайн өөрчлөлт газрын төрлөөр /Хавсралт-8/
- Байгалийн ойн нөөцийн өөрчлөлт /Хавсралт-9/
- Үндсэн ашиглалтын огтлолтын жилийн тооцоот хэмжээ /Хавсралт-10/
- Хэрэгжүүлэх шаардлагатай ойн аж ахуйн арга хэмжээ /Хавсралт-11/
- Хэрэгжүүлэх шаардлагатай ойн арчилгааны ажил /Хавсралт-12/
- Ойн сангийн талбайг ойн бүсээр ангилсан нь /Хавсралт-13/
- Хамгаалалтын бүсийн ойг аж ахуйн төрлөөр ангилсан нь /Хавсралт-14/
- Улсын тусгай хэрэгцээний газарт хамаарах ойн сангийн хэмжээ /Хавсралт-15/
- Ойн сангийн экологи-эдийн засгийн үнэлгээ /Хавсралт-16/




## 2. МОНГОЛ УЛСЫН ОЙН САН, ТҮҮНИЙ АНГИЛАЛ

Монгол улсын ойн сангийн талбай 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 18 608.0 мян.га байна. Энэ нь Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 11.9 хувийг эзэлж байна. Ойн сангийн талбайг төлөв байдлын хувьд ойн талбай, ойн бус талбай гэж 2 ангилах ба ойн талбайг дотор нь ойгоор бүрхэгдсэн талбай, ойгоор бүрхэгдээгүй талбай гэж ангилна.

Тухайн газар нутгийн ойрхог чанарыг тогтоохдоо ойгоор бүрхэгдсэн талбайгаар тооцож үнэлдэг. Монгол орны ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбай (улсын хэмжээний ойрхог чанар) нь нийт газар нутгийн 7.96 хувийг эзэлж байна.

Монгол улсын ойн сангийн талбайн 84.9 хувийг навч, шилмүүст ой, 15.1 хувийг заган ой эзэлнэ.

Бүдүүвч-1



Манай оронд 140 гаруй зүйлийн мод, сөөг тархан ургадаг бөгөөд навчит болон шилмүүст гэсэн 2 үндсэн ангилалд хуваагдана. Шинэс, нарс, хуш, гацуур, жодоо зэрэг нь шилмүүст модны ангилалд хамаардаг бол хус, улиас, улиангар, хайлаас, бургас, сөөг нь навчит модны ангилалд багтана.

Манай орны ойн сангийн зонхилогч гол мод нь шинэс бөгөөд байгалийн ойн талбайн 62,9 хувийг, нөөцийн 79,2 хувийг эзэлдэг.



### 3. ОЙН НӨӨЦ

Монгол орны ойн нөөц 1 248 642 118 шоо.метр байна. Ойн нөөцийн 79.2 хувийг шинэс, 4.9 хувийг нарс, 8.9 хувийг хуш, 0.23 хувийг гацуур, 0.01 хувийг жодоо, 5.9 хувийг хус, 0.18 хувийг улиас, 0.05 хувийг улиангар, 0.01 хувийг хайлаас, 0.28 хувийг бургас, 0.002 хувийг тоорой, 0.15 хувийг заган ойн нөөц эзэлнэ.

1-р хавсралт

#### Ой зохион байгуулалт хийгдсэн он дараалал

д/д	Аймгийн нэр	Ой зохион байгуулалт хийсэн он	Давтан ой зохион байгуулалт хийсэн он	Ойн сангийн талбай /мян.га/
1	Архангай	1995, 1996, 2008	2017	1 060.0
2	Баян-Өлгий	1985, 2008	2017	139.5
3	Баянхонгор	1991, 2006	2015	33.6
4	Булган	1997-1999, 2010	2018	1 922.2
5	Говь-Алтай	2005	2016	10.5
6	Говьсүмбэр		2017	0.05
7	Дорнод	2003	2012	244.1
8	Завхан	2006	2013	733.9
9	Өвөрхангай	1997, 2008	2016	176.0
10	Өмнөговь	-	2011	0.14
11	Сүхбаатар	-	2011	15.7
12	Сэлэнгэ	1992-1994	2017-2019	1 948.0
13	Төв	2007	2013	1 388.2
14	Увс	1990	2011	236.6
15	Ховд	-	2011	16.0
16	Хөвсгөл	2000-2003	2012	4 012.6
17	Хэнтий	2004, 2005	2013	1 754.7
18	Дархан-Уул	2006	2013	82.0
19	Улаанбаатар	1998, 2008	2016	116.3
20	Орхон	2001, 2010	2018	18.5
21	Дорноговь	1990, 2007	2015	0.12
Навчит, шилмүүст ойн сангийн талбай				13 908.5
1	Баянхонгор	1990, 2006	2015	787.2
2	Говь-Алтай	1990	2011	1 664.3
3	Дорноговь	1990, 2007	2015	116.9
4	Дундговь	1990, 2007	2015	32.8
5	Өвөрхангай	1990	2011	125.5
6	Өмнөговь	1990	2011	1 189.1
7	Ховд	1990	2011	783.8
Заган ойн /тоорой/ талбай				4 699.5
Улсын хэмжээгээр				18 608.0

Монгол орны ойн сангийн талбай /талбай-мянган га/

Аймгийн нэр	Ойгоор бүрхэгдсэн			Дүн	Ойгоор бүрхэгдээгүй							Дүн	Ойн талбайн Дүн	Ойн бус талбайн ДҮН	Бүх талбай
	Байгалийн ой	Сөөг торлог	Таримал ой		Тармаг мод	Шатсан талбай	МБ талбай	Ойжих талбай	Ойжуулсан талбай	хшөн талбай	ЦУ талбай				
Аймаг тус бүрийн газрын төрлийн нэгтгэл (шилмүүст, навчит)															
Архангай	852671	8034	-	860705	58166	61518	24102	11319	-	27902	-	183007	1043712	16285	1059997
Баян-Өлгий	96616	5038	-	101654	37564	96	125	45	-	-	-	37830	139484	-	139484
Баянхонгор	29795	65	-	29860	2443	327	-	844	-	-	-	3614	33474	89	33563
Булган	1343859	66880	210	1410949	118537	212214	26244	11969	1355	20625	-	390944	1801893	120312	1922205
Говь-Алтай	8980	-	-	8980	1407	-	-	6	-	-	-	1413	10393	63	10456
Говьсүмбэр	38	-	-	38	7	-	-	-	-	-	-	7	45	-	45
Дорнод	75396	15508	56	90960	28551	114864	1461	3072	257	0	-	148205	239165	4931	244096
Завхан	458490	43466	2	501958	43237	133102	10522	17984	0	1148	-	205993	707951	25951	733902
Өвөрхангай	144263	364	-	144627	14669	1698	4587	727	198	6748	-	28627	173254	2699	175953
Өмнөговь	142	-	-	142	-	-	-	-	-	-	-	-	142	-	142
Сүхбаатар	635	1583	-	2218	13445	-	-	-	1	-	-	13446	15664	-	15664
Сэлэнгэ	1419319	41874	7190	1468383	108706	226260	31717	20685	20301	331	457	408457	1876840	71132	1947972
Төв	957183	137857	142	1095182	49988	148517	7048	7133	1665	5645	-	219996	1315178	73021	1388199
Увс	197347	3552	30	200929	26678	2042	1971	629	-	26	-	31346	232275	4354	236629
Ховд	12394	-	-	12394	3578	-	-	-	-	-	-	3578	15972	20	15992
Хөвсгөл	3153151	123367	22	3276540	180851	352659	11333	15887	472	30670	-	591872	3868412	144152	4012564
Хэнтий	989733	186195	159	1176087	120166	391152	3411	11373	244	2638	-	528984	1705071	49666	1754737
Дархан-Уул	64805	1292	79	66176	7152	716	301	3114	0	15	-	11298	77474	4523	81997
Улаанбаатар	90647	4573	13	95233	4812	959	5756	1357	975	3685	-	17544	112777	3480	116257
Орхон	15851	-	-	15851	707	161	478	-	374	78	-	1798	17649	882	18531
Дорноговь	12	-	-	12	112	-	-	-	-	-	-	112	124	-	124
<b>дүн</b>	<b>9911327</b>	<b>639648</b>	<b>7903</b>	<b>10558878</b>	<b>820776</b>	<b>1646285</b>	<b>129056</b>	<b>106144</b>	<b>25842</b>	<b>99511</b>	<b>457</b>	<b>2828071</b>	<b>13386949</b>	<b>521560</b>	<b>13908509</b>
Ойрхог чанар (навчит шилмүүст)				6.75%	Ойн сангийн талбайг Монгол улсын нийт газар нутгийн хэмжээтэй харьцуулсан хувь										8.9%

Тайлбар: \*ХШӨН талбай - Хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн талбай, \*ЦУ талбай - Салхи цасанд унасан талбай

Аймгийн нэр	Ойгоор бүрхэгдсэн			Дүн	Ойгоор бүрхэгдээгүй							Дүн	Ойн талбайн Дүн	Ойн бус талбайн ДҮН	Бүх талбай
	Байгалийн ой	Сөөг торлог	Таримал ой		Тармаг мод	Шатсан талбай	МБ талбай	Ойжих талбай	Ойжуулсан талбай	хшөн талбай	СЦУ талбай				
<b>Аймаг тус бүрийн газрын төрлийн нэгтгэл (заг, тоорой)</b>															
Баянхонгор	509492	3121	-	512613	274401	8	-	128	-	-	-	274537	787150	2	787152
Говь-Алтай	461683	91273	-	552956	1078629	-	1003	31706	-	-	-	1111338	1664294	-	1664294
Дорноговь	54699	1132	-	55831	51487	-	-	9563	-	-	-	61050	116881	-	116881
Дундговь	16793	16	43	16852	14953	-	-	954	-	-	-	15907	32759	-	32759
Өвөрхангай	68523	9653	-	78176	24270	3744	-	19321	-	-	-	47335	125511	-	125511
Өмнөговь	604608	13486	-	618094	565731	815	587	3857	-	-	-	570990	1189084	-	1189084
Ховд	47313	11286	-	58599	725180	-	-	-	-	-	-	725180	783779	-	783779
заган ойн дүн	1763111	129967	43	1893121	2734651	4567	1590	65529	-	-	-	2806337	4699458	2	4699460
Ойрхог чанар (Заг)				<b>1.21%</b>	Заган ойн талбайг Монгол улсын нийт газар нутгийн хэмжээтэй харьцуулсан хувь										<b>3.0%</b>
<b>Нийт дүн</b>	<b>11 674 438</b>	<b>769 615</b>	<b>7 946</b>	<b>12 451 999</b>	<b>3 555 427</b>	<b>1 650 852</b>	<b>130 646</b>	<b>171 673</b>	<b>25 842</b>	<b>99 511</b>	<b>457</b>	<b>5 634 408</b>	<b>18 086 407</b>	<b>521 562</b>	<b>18 607 969</b>
Улсын хэмжээний ойрхог чанар				<b>7.96%</b>	Улсын ойн сангийн талбайг Монгол улсын газар нутгийн нийт хэмжээтэй харьцуулсан хувь										<b>11.9%</b>

Тайлбар:

- Ойгоор бүрхэгдсэн талбайд ойтой байгаа болон улсын ойн санд шилжүүлсэн таримал ой, бут сөөгөөр битүү хучигдсан талбай орно.
- Ойгоор бүрхэгдээгүй талбайд урьд өмнө ойтой байсан боловч ямар нэг шалтгаанаар ойгүй болсон талбай (мод бэлтгэсэн, ойн түймэр, хөнөөлт шавьж, өвчинд нэрвэгдсэн талбай гэх мэт) одоогийн байдлаар ойгүй боловч цаашидаа ой ургах нөхцөл бололцоотой газрууд (ойжиж байгаа газар, тармаг мод, ойжуулсан талбай гэх мэт) тус тус хамрагддаг.
- Ойн бус талбайд ойн сан доторх цагаан энгэр, таг царам, ойн цоорхой, мод үржүүлгийн талбай зэрэг газрууд ордог.



## Ойн сангийн байгалийн ойн талбай модны төрлөөр /талбай- га/

№	Аймаг	Модны төрөл														ДҮН
		шинэс	нарс	хуш	гацуур	жодоо	хус	улиас	улиангар	хайлаас	бургас	Навчит, шилмүүст модны дүн	Тоор ой	заг	Заг, тооройн дүн	
1	Архангай	824 577		13 102			2 185	3 618	131	35	9 023	852 671			-	852 671
2	Баян-Өлгий	84 727		256	441		83	1 921			9 188	96 616			-	96 616
3	Булган	1 030 951	31 037	17 665	257		245 476	1 011	190	1 870	15 402	1 343 859			-	1 343 859
4	Баянхонгор	29 534						94	29		138	29 795	514	508 978	509 492	539 287
5	Говь-Алтай	8 952						13			15	8 980	5	461 678	461 683	470 663
6	Говьсүмбэр										38	38				38
7	Дорнод	6 967	21 866				25 799	102	620		20 042	75 396			-	75 396
8	Төв	519 944	88 493	242 256	2 958		94 276	1 958	2 015		5 283	957 183			-	957 183
9	Хэнтий	696 232	45 043	66 752	39		154 815	8 800	1 383	74	16 595	989 733			-	989 733
10	Завхан	441 314		2 075	4 978		199	260	12		9 652	458 490			-	458 490
11	Увс	141 357		1 527	330		1 315	11 140			41 678	197 347			-	197 347
12	Сэлэнгэ	403567	293297	146269	5948	1045	535886	2605	8200	484	22018	1419319			-	1 419 319
13	Өвөрхангай	121 668		20 404			2 117		2		72	144 263		68 523	68 523	212 786
14	Хөвсгөл	2 975 465	2 204	86 099	4 694	36	71 215	2 492	251	127	10 568	3 153 151			-	3 153 151
15	Орхон	14 344					1 507					15 851			-	15 851
16	Улаанбаатар	50 126	11 315	16 520	1 442		6 871	1 939	30		2 404	90 647			-	90 647
17	Дархан-Уул		11 813				51 016		1 135	5	836	64 805			-	64 805
18	Сүхбаатар									143	492	635			-	635
19	Дундговь											-		16 793	16 793	16 793
20	Дорноговь										12	12	5	54 694	54 699	54 711
21	Өмнөговь									142		142	220	604 388	604 608	604 750
22	Ховд	5 024					1 372	39			5 959	12 394		47 313	47 313	59 707
	ДҮН	7354749	505068	612925	21087	1081	1194132	35992	13998	2880	169415	9911327	744	1 762 367	1 763 111	11 674 438
	Модны төрлийн эзлэх%	63.00	4.33	5.25	0.18	0.01	10.23	0.31	0.12	0.02	1.45	84.90	0.01	15.10	15.10	100.00

Монгол орны ойг бүрдүүлэгч моддоос зонхилон тархсан нь шинэс бөгөөд байгалийн ойн талбайн 63.0 хувьд тархан ургаж байна. Шинэсэн ой нь Хөвсгөл аймагт хамгийн их хэмжээгээр буюу 2 975 465 га талбайд тархан ургаж байна.

...

## Ойн сангийн байгалийн ойн нөөц модны төрлөөр /нөөц-шоо.метр/

Аймаг	Модны төрөл												Дүн
	Шинэс	Нарс	Хуш	Гацуур	Жодоо	Хус	Улиас	Улиангар	Хайлаас	Бургас	Тоорой	Заг	
Архангай	104112700	-	1914630	-	-	180580	317460	5420	1710	192820	-	-	<b>106725320</b>
Баян-Өлгий	8582090	-	17920	44330	-	3320	62090	-	-	126350	-	-	<b>8836100</b>
Булган	133324750	3376690	2739060	25870	-	15989260	58740	9990	51650	366000	-	-	<b>155942010</b>
Баянхонгор	2212570	-	-	-	-	-	2950	600	-	1550	10280	285428	<b>2513378</b>
Говь-Алтай	775870	-	-	-	-	-	250	-	-	180	250	488195	<b>1264745</b>
Говьсүмбэр	-	-	-	-	-	-	-	-	-	860	-	-	<b>860</b>
Дорнод	804130	2133460	-	-	-	1185970	3580	15010	-	408430	-	-	<b>4550580</b>
Төв	77216180	11637080	50453900	413700	-	6467270	120950	138890	-	130850	-	-	<b>146578820</b>
Хэнтий	88172450	5255030	9524550	3750	-	5844010	525820	67860	1410	280250	-	-	<b>109675130</b>
Завхан	56745090	-	282370	651930	-	8510	7800	840	-	190470	-	-	<b>57887010</b>
Увс	18906650	-	249720	34070	-	44120	707330	-	-	1022410	-	-	<b>20964300</b>
Сэлэнгэ	58636530	36202060	27145460	866090	150820	37017370	184460	355900	11830	434950	-	-	<b>161005470</b>
Өвөрхангай	15372810	-	3246030	-	-	85490	-	20	-	990	-	52091	<b>18757431</b>
Хөвсгөл	416080140	368070	12748400	599000	2520	3872710	144980	18760	5180	183560	-	-	<b>434023320</b>
Орхон	1550380	-	-	-	-	84090	-	-	-	-	-	-	<b>1634470</b>
Улаанбаатар	6829680	1482010	2893540	191290	-	385170	104270	2050	-	48230	-	-	<b>11936240</b>
Дархан-Уул	-	1302460	-	-	-	3209140	-	62460	50	13330	-	-	<b>4587440</b>
Сүхбаатар	-	-	-	-	-	-	-	-	3490	6070	-	-	<b>9560</b>
Дундговь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	5502	<b>5502</b>
Дорноговь	-	-	-	-	-	-	-	-	-	120	220	27783	<b>28123</b>
Өмнөговь	-	-	-	-	-	-	-	-	5680	-	14980	939062	<b>959722</b>
Ховд	560870	-	-	-	-	47390	1650	-	-	136470	-	10207	<b>756587</b>
<b>ДҮН</b>	<b>989882890</b>	<b>61756860</b>	<b>111215580</b>	<b>2830030</b>	<b>153340</b>	<b>74424400</b>	<b>2242330</b>	<b>677800</b>	<b>81000</b>	<b>3543890</b>	<b>25730</b>	<b>1808268</b>	<b>1248642118</b>
эзлэх хувь	79.2	4.9	8.9	0.2	0.01	5.9	0.17	0.05	0.006	0.2	0.002	0.14	100

Ойн нөөц гэдэг нь 1 га ой дахь ургаа модны ишний нийт эзлэхүүнийг хэлнэ. Монгол орны байгалийн ойн нийт нөөц 124 862 118 шоо.метр. Үүнээс шинэсэн ойн нөөц хамгийн их буюу 79.2 хувийг эзэлж байна.

## Шилмүүст, навчит ойг насны бүлгээр ангилсан нь /талбай-га, нөөц-шоо.метр/

Модны төрөл	Насны бүлэг								Дүн	
	Залуу ой		Дунд насны ой		Болц гүйцэж яваа ой		Болц гүйцсэн ХӨГШИН ОЙ			
	Талбай	Нөөц	Талбай	Нөөц	Талбай	Нөөц	Талбай	Нөөц	Талбай	Нөөц
Навчит шилмүүст ой										
Шинэс	36 708	1 776 480	969 032	99 255 430	669 513	83 798 600	5 679 496	805 052 380	7 354 749	989 882 890
Нарс	13 293	549 420	110 021	9 974 310	79 108	9 345 220	302 646	41 887 910	505 068	61 756 860
Хуш	14 478	1 162 880	56 610	8 139 310	310 155	55 492 320	231 682	46 421 070	612 925	111 215 580
Гацуур	-	-	2 978	301 260	5 477	703 550	12 632	1 825 220	21 087	2 830 030
Жодоо	-	-	212	19 560	182	20 800	687	112 980	1 081	153 340
Хус	109 934	2 567 460	432 080	22 040 980	366 617	26 370 170	285 501	23 445 790	1 194 132	74 424 400
Улиас	452	13 100	11 004	544 620	5 882	378 420	18 654	1 306 190	35 992	2 242 330
Улиангар	4 937	118 750	6 331	354 920	1 701	132 740	1 029	71 390	13 998	677 800
Хайлаас	243	8 790	1 798	51 990	529	8 140	310	12 080	2 880	81 000
Бургас	51 456	885 970	117 622	2 651 280	337	6 640	-	-	169 415	3 543 890
<b>Дүн</b>	<b>231 501</b>	<b>7 082 850</b>	<b>1 707 688</b>	<b>143 333 660</b>	<b>1 439 501</b>	<b>176 256 600</b>	<b>6 532 637</b>	<b>920 135 010</b>	<b>9 911 327</b>	<b>1 246 808 120</b>
эзлэх %	<b>2.34</b>	<b>0.57</b>	<b>17.23</b>	<b>11.50</b>	<b>14.52</b>	<b>14.14</b>	<b>65.91</b>	<b>73.80</b>	<b>100.00</b>	<b>100.00</b>

Ойн нөөцөд насны бүлгийн эзлэх хувь



Навч, шилмүүст ойн нөөцийг техникийн болцоор тооцож насны бүлгээр ангилж үзвэл талбайн 14.5 хувь, нөөцийн 14.1 хувийг болц гүйцэж яваа, талбайн 65.9 хувь, нөөцийн 73.8 хувийг болц гүйцсэн, хөгшин ой эзэлж байна.

## Заган ойг насны бүлгээр ангилсан нь /талбай-га, нөөц-шоо.метр/

Аймаг	Н а с н ы   б ү л э г										Дүн	
	Залуу заг		Дунд насны заг		Болц гүйцэж яваа заг		Болц гүйцсэн заг		Хөгшин заг			
	талбай	нөөц	талбай	нөөц	талбай	нөөц	талбай	нөөц	талбай	нөөц	талбай	нөөц
Баянхонгор	252	19	4840	759	151653	71371	324448	188788	27785	24488	508 978	285 425
Говь-Алтай	13308	2596	20241	9472	100736	122737	275834	330903	51559	22484	461 678	488 192
Дорноговь	-	-	-	-	-	-	4410	1096	50284	26684	54 694	27 780
Дундговь	-	-	-	-	-	-	328	65	16465	5436	16 793	5 501
Өвөрхангай	5817	1749	3277	811	8415	3415	19319	13675	31695	32438	68 523	52 088
Өмнөговь	8225	2625	10806	3528	15170	10576	323100	401810	247087	520519	604 388	939 058
Ховд	987	197	41156	8625	3068	725	2102	659			47 313	10 206
<b>Дүн</b>	<b>28589</b>	<b>7186</b>	<b>80320</b>	<b>23195</b>	<b>279042</b>	<b>208824</b>	<b>949541</b>	<b>936996</b>	<b>424875</b>	<b>632049</b>	<b>1 762 367</b>	<b>1 808 250</b>
<b>Эзлэх хувь</b>	<b>1,62%</b>	<b>0,40%</b>	<b>4,56%</b>	<b>1,28 %</b>	<b>15,83%</b>	<b>11,55%</b>	<b>53,88 %</b>	<b>51,82%</b>	<b>24,11%</b>	<b>34,95%</b>	<b>100%</b>	<b>100%</b>

Заган ойн нөөцөд насны бүлгийн эзлэх хувь



Монгол орны заган ойн нөөцийг насны бүлгээр авч үзвэл 0.40 хувийг залуу заг, 1.28 хувийг дунд насны заг, 11.55 хувийг болц гүйцэж яваа заг, 51.82 хувийг болц гүйцсэн заг, 34.95 хувийг хөгшин заган ой эзэлж байна.

## Байгалийн ойн таксацын дундаж үзүүлэлт модны төрлөөр

Модны төрөл	Байгалийн ойн талбай /га/	Бүх нөөц /ш.м/	Б.Г.Х ойн талбай /га/	Б.Г.Х ойн нөөц /ш.м/	Бүх дундаж өсөлт /ш.м/	Дундаж			Б.Г.Х ойн 1 га-н нөөц /ш.м/	Ойгоор бүрхэгдсэн талбайн 1 га-н	
						Нас /жил/	Бонитет	Өтгөрөл		нөөц /ш.м/	өсөлт /ш.м/
Шинэс	7 354 749	989 882 890	5 679 496	805 052 380	7 139 255	138.65	4.26	0.50	141.75	134.59	0.97
Нарс	505 068	61 756 860	302 646	41 662 910	530 794	116.35	4.06	0.50	137.66	122.27	1.05
Хуш	612 925	111 215 580	231 682	46 421 070	757 764	146.77	4.52	0.51	200.37	181.45	1.24
Гацуур	21 087	2 830 030	12 632	1 825 220	24 161	117.13	4.23	0.49	144.49	134.21	1.15
Жодоо	1 081	153 340	687	112 980	1 160	137.56	4.01	0.53	164.45	141.85	1.07
Хус	1 194 132	74 424 400	285 501	23 445 790	1 525 110	48.80	4.09	0.51	82.12	62.33	1.28
Улиас	35 992	2 242 330	18 654	1 306 190	35 639	63.10	4.24	0.49	70.02	62.30	0.99
Улиангар	13 998	677 800	1 029	71 390	17 040	40	4.14	0.51	69.38	48.42	1.22
Хайлаас	2 880	81 000	310	12 080	1 999	40.64	4.12	0.42	38.97	28.13	0.69
Бургас	169 415	3 543 890	-	-	152 915	23.18	4.42	0.40	-	20.92	0.90
<b>Дүн</b>	<b>9 911 327</b>	<b>1 246 808 120</b>	<b>6 532 637</b>	<b>919 910 010</b>	<b>10 185 836</b>	<b>-</b>	<b>4.23</b>	<b>0.51</b>	<b>141.79</b>	<b>125.80</b>	<b>1.03</b>
Заг	1 762 367	1 808 250	5 384	7 306	65 370	27.66	2.93	0.34	1.36	1.03	0.04
Тоорой	744	25 730	-	-	347	74	3,01	0.41	-	34.58	0.47
<b>Дүн</b>	<b>1 763 111</b>	<b>1 833 980</b>	<b>5 384</b>	<b>7 306</b>	<b>65 717</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>11 674 438</b>	<b>1 248 642 100</b>	<b>6 538 021</b>	<b>919 917 316</b>	<b>10 251 553</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Монгол орны ойн сангийн байгалийн ойн таксацын дундаж үзүүлэлтийг харахад шилмүүст үүлдрийн модны дундаж нас 131.3 жил, навчит үүлдрийн модны дундаж нас 43.1 жил, болц гүйцсэн хөгшин шилмүүст ойн 1 га талбайн нөөц 157.7 шоо.метр, навчит ойн 1 га талбайн нөөц 52.1 шоо.метр байна.

Ойгоор бүрхэгдсэн 1 га талбайн нөөцийг шилмүүст, навчит үүлдрээр ангилж үзвэл шилмүүст ойн 1 га талбайн нөөц 142.8 шоо.метр, навчит ойн 1 га талбайн нөөц 44.4 шоо.метр байна.

Ойгоор бүрхэгдсэн талбайн 1 га талбайн өсөлт шилмүүст үүлдрийн ойд 1.1 шоо.метр байхад навчит үүлдрийн ойд 1.02 шоо.метр байна. Монгол орны ойн сангийн жилийн бүх дундаж өсөлт шилмүүст навчит модонд 10 185 836 шоо.метр, нийт 10 251 553 шоо.метр байна.

## Ойн сангийн газрын төрлийн өөрчлөлт (талбай мянган.га)

Үзүүлэлт	2015 он	2019 он	Зөрүү
Монгол орны газар нутгийн хэмжээ	156411.6	156411.6	-
Ойн сангийн нийт талбай	18454.8	18621.1	166.3
Ойгоор бүрхэгдсэн	12280	12452.0	172.0
Байгалийн ой	11500.4	11674.4	174.0
Сөөг, торлог	777.5	769.6	-7.9
Таримал ой	2.1	7.9	5.8
Ойрхог чанар, %	7.85	7.96	0.11
Ойгоор бүрхэгдээгүй талбайн дүн	5631.3	5634.4	3.1
Тармаг модод	3495.4	3555.4	60.0
Түймэрт нэрвэгдсэн	1703.9	1646.3	-57.6
Мод бэлтгэсэн	106.1	130.6	24.5
Байгалийн аясаар ойжиж байгаа	174	171.7	-2.3
Зориудаар ойжуулсан	10.7	25.8	15.1
Хөнөөлт шавжид нэрвэгдсэн	135.7	99.5	-36.2
Салхи цасанд унасан ой	0.9	0.5	-0.4
Хатсан заг	4.6	4.6	0.0
Ойн талбайн дүн	17911.3	18086.4	175.1
Ойн бус талбай	543.5	534.7	-8.8
Ойрхог чанар ойн сангийн нийт талбайгаар, %	11.8	11.9	0.1

Ойн санд гарсан өөрчлөлтийг тооцохдоо 2015 оны ойн сангийн газрын төрлөөр ангилсан дүн мэдээг 2019 оны ойн сангийн шинэчлэгдсэн дүн мэдээтэй харьцуулж 5 жилийн хугацаанд гарсан зөрүүг тооцож гаргав.

Ойн сангийн өөрчлөлтийг гаргасан хүснэгтээс харахад ойгоор бүрхэгдсэн талбайн ангилалд байгалийн ой 172.0 мян.га, таримал ой 5.8 мян.га-аар нэмэгдэж, сөөг, торлог 7.9 мян.га талбайгаар багасаж, ойгоор бүрхэгдсэн талбай нийт дүнгээрээ 17260 мян.га талбайгаар нэмэгдсэн байна.

Харин ойгоор бүрхэгдээгүй талбайн ангилалд тармаг модод 60.0 мян.га, мод бэлтгэсэн талбай 24.5 мян.га, зориудаар ойжуулсан талбай 15.1 мян.га талбайгаар нэмэгдэж, Түймэрт нэрвэгдсэн талбай 57.6 мян.га, байгалийн аясаар сэргэн ургаж буй талбай 2.3 мян.га, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн талбай 36.2 мян.га, салхи цасанд унасан талбай 0.4 мян.га талбайгаар багассан нь ойн сангийн ойгоор бүрхэгдээгүй талбай 3.1 мян.га талбайгаар нэмэгдэх гол хүчин зүйл болсон байна.

Монгол орны ойн сангийн сүүлийн 5 жилийн хугацааны цаг үеийн мэдээний өөрчлөлтөд дараах хүчин зүйлүүд нөлөөлж байна.

Ойн сангийн нийт талбай багасаж гарсан нэг шалтгаан нь 2009 оноос эхлэн ой зохион байгуулалтын зураглалын ажилд Засгийн газрын 2009 оны 25-р тогтоолоор баталсан стандартын дагуу проекцын шинэчлэл хийгдсэн явдал юм.

Мөн ой зохион байгуулалтын ажилд орон зайн нарийвчлал сайтай хиймэл дагуулын мэдээг (зарим тохиолдолд өндөр нарийвчлалын сансрын зураг) ашиглаж байгаатай холбоотой.

Олон зорилтот ойн тооллогын ажлын арга менежментэд тулгуурлан 2017 оноос эхлэн ойн бүрхэвчийн үнэлгээ хийх, Collect Earth программаар газар ашиглалтын үнэлгээг хийж ой зохион байгуулалтын давтан зохион байгуулалтын ажлын ойн тархалтын талбайг тодорхойлж, дээж талбай байгуулан ойн сангийн үзүүлэлтийг нарийвчлан тогтоож байгаа нь ойн сангийн өөрчлөлтийг гаргахад ойн сангийн газрын төрлийн нарийвчлал нь өмнөх онуудад хийгдэж байсан зураглалын ажлаас чанарын хувьд дээшилсэн гэж дүгнэж байна.

Ойн бус талбай багасаж гарсан нь ойн сан бүхий газрын тал хээртэй шууд хил залгаа том хэмжээний хадлан, бэлчээр, цагаан энгэр зэрэг хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг ойн сангийн талбайгаас хасаж тооцсонтой холбоотой үүссэн өөрчлөлт юм.

## Байгалийн ойн нөөцийн өөрчлөлт /нөөц- мянган шоо.метр/

Модны төрөл	2015 оны нөөц м.ш.м	2019 оны нөөц м.ш.м	Зөрүү нөөц м.ш.м
Шинэс	977 314.6	989882.9	12568.3
Нарс	61 857.5	61756.9	-100.7
Хуш	116 121.5	111215.6	-4905.9
Гацуур	2 861.7	2830.0	-31.6
Жодоо	238.8	153.3	-85.5
Хус	76 830.3	74424.4	-2405.9
Улиас	2 178.6	2242.3	63.7
Улиангар	677.5	677.8	0.3
Хайлаас	81.1	81.0	-0.1
Бургас	3 430.7	3543.9	113.2
Заг	1 808.3	1808.3	0.0
Тоорой	25.7	25.7	0.0
	1 243 426.3	1248642.1	5215.8

Ойн сангийн байгалийн ойн нөөцийн өөрчлөлтийг модны төрөл тус бүрээр авч үзвэл шилмүүст үүлдрийн моддоос шинэсэн ойн нөөц 12 568.3 мянган шоо.метрээр нэмэгдсэн бол бусад шилмүүст үүлдрийн модод болох нарсан ойн нөөц 100.7 мянган шоо.метр, хушин ойн нөөц 4905.9 мянган шоо.метр, Гацууран ойн нөөц 31.6 мянган шоо.метр, Жодоо ойн нөөц 85.5 мянган шоо.метрээр багассан байна. Энэ нь Нарс, Хуш, Гацуур, Жодоо ойн тархац нөөц нутаг болох Сэлэнгэ аймгийн ойн санд сүүлийн жилүүдэд гарсан ойн түймрийн нөлөөлтэй шууд хамааралтай гэж дүгнэж байна.

Харин навчит үүлдрийн хусан ойн нөөц 2405.9 мянган шоо.метр, Хайлаасан ойн нөөц 0.1 мянган шоо.метрээр буурсан бол бусад навчит үүлдрийн ойн нөөц өссөн дүнтэй гарсан байна. Ойн сангийн нийт нөөц 5 215.8 мянган шоо.метрээр нэмэгдсэн байна. Нөөцийн дүн өссөн гол шалтгаан нь ойд хийж буй ойн таксацын арга барилаас хэмжилтэд тулгуурласан арга барилд шилжсэн, мөн зарим газарт ургаж буй ойн санг бүрэн хамруулсан зэрэг шалтгаанаас үүдэлтэй байна.

Заган ойн талбай, нөөц нэмэгдэж гарсан явдал нь 1990 оноос хойш ой зохион байгуулалтын судалгаанд хамрагдаагүй Говь-Алтай, Ховд, Өмнөговь аймгийн заган ойн санд 2011 онд, Дундговь, Дорноговь аймгийн заган ойн санд 2015 онд давтан ой зохион байгуулалтын ажил хийгдэж тухайн аймгуудын ойн сангийн талбайн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой. Мөн говь цөлийн нэн ховор мод болох тоорой нь бүртгэлгүй байсныг улсын ойн санд бүртгэж авснаар заг, тооройн ойн нөөц нэмэгдэж гарлаа.



Үндсэн ашиглалтын огтлолын жилийн тооцоот мод бэлтгэлийн хэмжээ  
(талбай-га, нөөц- мянган.шоо.метр/

д/д	Аймгийн нэр	Огтлолын төрөл /талбай-га, нөөц-мянган.шоо.метр/			
		Түүвэрлэх огтлолт			
		Төлөвлөсөн ойн талбай		Жилд бэлтгэх хэмжээ	
		талбай	нөөц	талбай	нөөц
1	Архангай	21809	3577.3	725	18.8
2	Булган	14 348	1966.5	542	13.8
3	Төв	17776	3080.9	592	11.9
4	Хэнтий	36085	5573.5	1104	17.5
5	Завхан	8438	1359.1	280	2.2
6	Сэлэнгэ	58600	7884.2	2142	70.9
7	Хөвсгөл	160626	25994.1	5490	131.6
8	Дорнод	1459	214.2	90	1.0
<b>Нийт дүн</b>		<b>319 141</b>	<b>49 649.8</b>	<b>10 965</b>	<b>267.7</b>

Монгол улсын "Ойн тухай" хуулийн 9 дүгээр зүйл 9.1 заалтын дагуу 8 аймгийн ойн санд ашиглалтын бүс тогтоосон. Ашиглалтын бүсийн ойд сонгон түүвэрлэх огтлолын аргаар мод бэлтгэхийг зөвшөөрдөг бөгөөд авч ашиглах боломжит дээд хязгаарыг тооцсон хүснэгтээс харахад сонгон түүвэрлэх аргаар жилд 10 965 га талбайгаас 267.7 мянган шоо.метр модыг үндсэн ашиглалтаар авч ашиглах боломжтой байна.

## Хэрэгжүүлэх шаардлагатай ойн аж ахуйн арга хэмжээ /талбай-га, нөөц- шоо.метр/

д/д	Аймгийн нэр	Талбай /га/	Нөөц /шоо.метр/		Ойжуулалтын арга хэмжээ / талбай га/		
			Хатсан мод	Унанги мод	Ойжуулалт хийх	БСУТуслах ажил	Өсвөр модыг хамгаалах
1	Архангай	96953	2854170	1585460	8644	11620	66148
2	Сэлэнгэ	177396	2462020	963530	19676	53221	15267
3	Төв	478337	2930202	9272710	16996	6704	
4	Завхан	111743	3112400	1039850	11612		
5	Улаанбаатар	13077	184220	86900	11477	4300	610
6	Өвөрхангай	31151	516200	423530	11467	18959	
7	Баян-Өлгий	8680	173950	86450	871	3247	15571
8	Булган	103099	3071150	377720	10427	7159	26465
9	Хөвсгөл	827373	13598889	5618355	45652	60523	10835
10	Дархан-Уул	1526	15935		3979	7680	
11	Дорнод	53730	528590	275520	114732	32076	
12	Орхон	319	1350	3140	363	533	
13	Говь-Алтай	1311	13520	29840	165	1693	
14	Хэнтий	608560	7746320	3147570	3736		
15	Увс	16586	248410	166540	26678	629	
16	Баянхонгор	310	11380				
17	Сүхбаатар				13445		
<b>Ойн дүн</b>		<b>2 530 151</b>	<b>37 468 706</b>	<b>23 077 115</b>	<b>299 920</b>	<b>208 344</b>	<b>134 896</b>
Заган ой							
1	Өмнөговь				1 402	564 407	3 857
2	Говь-Алтай					222 769	
3	Өвөрхангай				4 845	16 568	
4	Дорноговь					8 448	8 165
5	Дундговь					6 688	4 939
6	Баянхонгор					9 151	4 557
<b>Заган ойн дүн</b>		<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>6 247</b>	<b>828 031</b>	<b>21 518</b>
<b>Нийт дүн</b>		<b>2 530 151</b>	<b>37 468 706</b>	<b>23 077 115</b>	<b>306 167</b>	<b>1 036 375</b>	<b>156 414</b>

Улсын хэмжээгээр 2 530 151 га талбайд 37 468.7 мянган шоо.метр хатсан мод, 23 077.1 мянган шоо.метр унанги модны нөөц бүртгэгдсэн байна.

## Хэрэгжүүлэх шаардлагатай ойн арчилгааны ажил / нөөц-шоо.метр/

д/д	Аймгийн нэр	Арчилгааны төрөл									
		Гэрэлжүүлэх		Тохируулах		Сийрүүлэх		Завсрын		Дүн	
1	Архангай	158	890	4 212	40 000	3 867	51 540	5 646	112 920	13 883	205 350
2	Сэлэнгэ	1066	7600	36156	497 160	36 858	206 450	24 360	79 700	98 440	790 910
3	Төв	20	970	1 215	51 340	1 879	142 240	4 498	832 150	7 612	1 026 700
4	Завхан					421	31 480	1 004	139 130	1 425	170 610
5	Баянхонгор					207	2 470	378	5 350	585	7 820
6	Улаанбаатар			18	1 040	231	19 170	1 908	261 880	2 157	282 090
7	Өвөрхангай			101	7360	259	22 760	1 026	106 810	1 386	136 930
8	Баян-Өлгий			11	660	282	31 200	699	69 010	992	100 870
9	Булган	44	3 300	123	9 680	243	29 580	1 852	294 760	2 262	337 320
10	Хөвсгөл	145	4 460	2 461	147 220	5 412	521 250	21 339	2 660 390	29 357	3 333 320
11	Дархан-Уул			1 251	34 610	1 005	45 660	290	21 640	2 546	101 910
12	Дорнод			692	16 150	85	2 450	395	50 730	1 172	69 330
13	Орхон							36	5 620	36	5 620
14	Хэнтий			893	32 700	2 744	257 820	2 480	322 660	6 117	613 180
15	Говь-Алтай			13	1 430	157	10 000			170	11 430
16	Увс	468	73 050			503	76 820	55	9 310	1 026	159 180
	<b>Нийт дүн</b>	<b>1901</b>	<b>90 270</b>	<b>47 146</b>	<b>839 350</b>	<b>54 153</b>	<b>1 450 890</b>	<b>65 966</b>	<b>4 972 060</b>	<b>169 166</b>	<b>7 352 570</b>

Улсын хэмжээгээр 16 аймаг, 1 хотын ойн санг хамруулан гэрэлжүүлэх хэлбэрийг 90.3 мянган шоо.метр нөөц бүхий 1901 га талбайд, тохируулах хэлбэрийг 839.3 мянган шоо.метр нөөц бүхий 47 146 га талбайд, сийрүүлэх хэлбэрийг 1 450.9 мянган шоо.метр нөөц бүхий 54 153 га талбайд, завсрын хэлбэрийг 4 972.1 мянган шоо.метр нөөц бүхий 65 966 га талбайд, нийт 7 352.6 мянган шоо.метр нөөц бүхий 169 166 га талбайд ойн арчилгааны арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэж төлөвлөсөн байна.

## Ойн сангийн талбайг ойн бүсээр ангилсан нь /талбай- га/

д/д	Аймгийн нэр	Аж ахуйн бүс		Нийт дүн
		Хамгаалалт	Ашиглалт	
1	Архангай	911440	148557	1059997
2	Баян-Өлгий	139484	-	139484
3	Баянхонгор	33563	-	33563
